

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 06 дугаар сарын 20


Арвайхээр

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих	Байгууллагын үнэлгээ	Аймгийн ЗДТГазар үнэлгээ
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг "Санхүүгийн хяналт, аудитын алба" фээсбүүк болон <a href="http://www.sankhuuhuanalt.ov.gov.mn">www.sankhuuhuanalt.ov.gov.mn</a> цахим хуудасны зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсэгт байршуулж 2242 иргэнд хүргэсэн. 1.2. Авлигын эсрэг иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээнд оролцох	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн "Нэгдье 110", "Авч буй мэдээлэлдээ хянамгай хандаарай" инфографикийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр, албаны "Санхүүгийн хяналт, аудитын алба" гэсэн фээсбүүк хуудас болон <a href="http://www.sankhuuhuanalt.ov.gov.mn">www.sankhuuhuanalt.ov.gov.mn</a> цахим хуудасны ил тод байдал цэсний авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэсэгт байршуулж 2242 иргэнд хүргэсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс "Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах өдөрлөг"-2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахад хамтран оролцож, Шилэн дансны болон Авлигын эсрэг хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан, мэдээлэл өглөө.	100	
2.	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	1.3. Өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий брошур бэлтгэж олон нийтэд хүргэсэн байх. 2.1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг сургалтад албан хаагчдыг хамруулах	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах өдөрлөгийн үеэр Шилэн дансны хуулийн тухай мэдээлэл бүхий гарын авлага, авлигын эсрэг сурталчилгааны мэдээлэл агуулсан зурагт хуудас, албаны ерөнхий танилцуулга бүхий түүхүүрийн оосор бэлтгэн 35 иргэн, төрийн албан хаагчдад тараасан. 2024 оны 01 дүгээр сарын 09-нд ЭБАТ-уудад зориулсан сургалт, 05 дугаар сарын 07-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолыг танилцуулах сургалтад тус тус хамрагдсан.	100	
3.	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1. Байгууллагын үйл ажиллагааны явцад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэнтэй гэрээ байгуулах тохиолдолд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг	2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр НИК ХК-тай шатахуун нийлүүлэх гэрээ байгуулахдаа хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг	100	

	<p>сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулж, шилэн данс, цахим хуудсандаа байршуулах</p> <p>3.2. Байгууллагын <a href="http://www.sankhuuhyanalт.ov.gov.mn">www.sankhuuhyanalт.ov.gov.mn</a> цахим хуудсанд хандагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг байхаар цахим хуудасны хөгжүүлэлтийг хийх.</p> <p>3.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулах.</p>	<p>албаны дарга гаргаж, аймгийн Засаг даргаар баталгаажуулсан.</p> <p>Байгууллагын <a href="http://www.sankhuuhyanalт.ov.gov.mn">www.sankhuuhyanalт.ov.gov.mn</a> цахим хуудсанд хандагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг байхаар цахим хуудасны хөгжүүлэлтийг хийх бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу <a href="http://www.sankhuuhyanalт.ov.gov.mn">www.sankhuuhyanalт.ov.gov.mn</a> цахим хуудсандаа судалгаа цэсэнд статистик мэдээ гэсэн хэсэг үүсгэж, 2019-2023 оны 4 дүгээр улирлын шилэн дансны мэдээллийг графикаар байршуулсан.</p>	<p>30</p> <p>100</p>
<p>4</p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p>	<p>4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх боловсон хүчний томилгоо хийх, хяналт шалгалт, дотоод аудит хийх тухай бүр хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, шилэн данс болон цахим хуудсандаа байршуулж, олон нийтэд хүргэх.</p>	<p>2024 оны эхний хагас жилд албаны даргын тушаал шийдвэртэй холбоотой 1, дотоод аудит, хяналт шалгалттай холбоотой 46 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулан бүртгэл хяналтын дэвтэрт бүртгэж сар бүр шилэн дансанд <a href="http://www.sankhuuhyanalт.ov.gov.mn">www.sankhuuhyanalт.ov.gov.mn</a> цахим хуудасны "ил тод" цэсний "авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" хэсэгт сар бүр байршуулсан. Meduileg.iaas.mn цахим хуудсанд мэдээллийг тухай бүр оруулж байна.</p>	<p>100</p>

ДАРГА

М.ЭРДЭНЭЧУЛУУН



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

С.ДУЛАМЖАРГАЛ